

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЦЭЦИЙН ДАРГА Н.ЧИНБАТ ТАНАА

Хүсэлт

2021-04-12

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг ... Цэцийн аль нэг гишүүн эс зөвшөөрч ... санал бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана." гэж заасан байдаг.

Хуулиар олгосон энэхүү эрх үүргийнхээ хүрээнд, нэр бүхий иргэдээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд "өмнө нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилласан иргэнийг бүртгэхгүй байх шаардлагыг орхигдуулан хуульчилсан нь" Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн талаар мэдээлэл ирүүлснийг хүлээн авсан Цэцийн гишүүн Д.Солонго маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэснийг хэд хэдэн үндэслэлээр эсэргүүцэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хянан шийдвэрлүүлэхийг хүсч саналаа гаргасан билээ.

Миний энэ саналыг таны томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдөр хэлэлцэж эхэлсэн. Гэтэл уг хуралдааны бүрэлдэхүүнд оролцсон зарим гишүүн хуралдаан шийдвэрээ гаргасан гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн бол Цэцийн хэвлэл мэдээллийн албанаас хуралдаан үргэлжилж байгаа гэсэн мэдэгдлийг гаргасан. Ийнхүү хуралдаан шийдвэрээ гаргасан эсвэл хойшилсон, завсарласан эсэх нь тодорхойгүй байхад хуралдааны бүрэлдэхүүнд нөхөн томилогдсон Цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган асуудлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай адилаар авч үзэж, "ажиллагааг шинээр эхлэж" миний саналыг "шалгаад", хэлэлцэх боломжгүй гэсэн тогтоол гаргасан байна.

Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргуулахаар гаргасан мэдээлэл, өргөдөл, хүсэлтээр үүсгэдэг. Гэтэл би маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн нь зөв эсэхийг шийдвэрлүүлэхээр санал гаргасан. Тийм учраас миний саналыг хуульд тодорхой заасны дагуу "Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар" шууд хэлэлцэж шийдвэрлэх ёстой.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг **маргагч талууд** буюу **Цэцийн аль нэг гишүүн** эс зөвшөөрч гомдол, санал бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана." гэж тодорхой заасан байтал Цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган тогтоолдоо Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг зөвхөн маргагч талууд эс зөвшөөрч гомдол гаргавал Бага суудлын хуралдаанаар хэлэлцэхээр зохицуулснаас биш гишүүн санал гаргахад хэрхэх талаар эрх зүйн зохицуулалтгүй байгаа мэтээр хуулийн заалтыг илтэд гуйвуулан дурджээ.

Мөн намайг хянан шалгаж байгаа маргааны талаархи саналаа урьдчилан илэрхийлсэн мэтээр тогтоолдоо дурдсан байна. Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн талаар ирүүлсэн мэдээллийг хүлээн авч хянан шалгаж байгаа гишүүн нь Д.Солонго болохоос би биш. Иймд уг мэдээлийн талаар миний бие саналаа "урьдчилан илэрхийлэх" боломжгүй юм.


Цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган дээрх тогтоолдоо миний саналыг "Үндсэн хуулийн маргааны шинжид хамааралгүй, хувийн дүгнэлтээ дурдсан" гэжээ. Миний гаргасан санал Үндсэн хуулийн маргаанд хамаарахгүй тул маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай адилтган шийдвэрлэж болохгүй гэдгийг дээр дурдсан, мөн Цэцийн гишүүн өөрийн "хувийн дүгнэлт" буюу өөрийн дотоод итгэл үнэмшлээрээ асуудалд хандах ёстойг манай процессийн хуулинд тодорхой заасан байдаг.

Миний гаргасан санал нэг гишүүний тогтоолоор биш Цэцийн даргын томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар дэмжигдэх эсвэл няцаагдаж хэрэгсэхгүй болох ёстойг дахин дурдъя.

Иймд Үндсэн хуулийн цэцийн гишүүний саналыг хуульд заасны дагуу шийдвэрлээгүй байхад дээрх асуудлаар Цэцийн дунд суудлын хуралдаан зарлаж, Цэцийн дарга уг хуралдааны бүрэлдэхүүнийг томилсныг миний бие эс зөвшөөрч байгаа тул Цэцийн гишүүн Д.Солонгын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэснийг эсэргүүцэж гаргасан миний саналыг хуулийн дагуу эцэслэн шийдвэрлэхэд анхаарал хандуулахыг танаас хүсье.

Хувийг, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Солонго, Д.Одбаяр, Г.Баясгалан, Ц.Нанзаддорж танаа

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮН



Б.БУЯНДЭЛГЭР